

МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗЭЭЛЛЭГИЙГ ТОЙРСОН АСУУДЛУУД (1911-1917 он)

Г.Цэнджав

Товч утга: Туурга тусгаар улсаа 1911 оны 12 дугаар сарын 29-нд байгуулсан Монгол улс нь үндэсний эрх чөлөөний хувьсгалын ололтоо цаашид бэхжүүлэн газар нутгаа манж-хятадын цэргээс бүрэн чөлөөлж, улмаар олон монгол овогтноо нэгтгэхийн тулд шинэ Засгийн газарт ихээхэн хэмжээний сан мөнгө хэрэгцээтэй байлаа. Гэтэл эл үед монголын аж ахуйн хөгжлийн түвшин зохих хэмжээний хуримтлалыг буй болгож чадахгүй байсан тул “Монгол Улсын засгийн хэрэг ба цэргийн байдал, жич улсын сангийн явдлыг сайжруулахад зарцуулах” зорилгоор удаа дараа Хаант Оросоос тусламж, зээл авч байв. Тийнхүү Монгол улс хувьсгалын зорилтуудаа хэрэгжүүлэхийн тулд хойш хөршөөсөө нилээд хэмжээний зээл авч, улмаар эргүүлэн төлж байсан боловч үлэмжхэн хэмжээний өртэй байсан болсон бөгөөд Орос оронд тогтсон ажилчин тариачны Зөвлөлийн засаг Монголын өрийг хүчингүй болгосон билээ.

Түлхүүр үг: Зээл тусламж, эдийн засгийн чадавч, гааль татвар түрээс, Хаант Оросын бодлого, Монгол улсын Засгийн газар, Улсын Дээд Доод хурал

Туурга тусгаар улсаа 1911 оны 12 дугаар сарын 29-нд байгуулсан Монгол улс нь үндэсний эрх чөлөөний хувьсгалын ололтоо цаашид бэхжүүлэн газар нутгаа манж-хятадын цэргээс бүрэн чөлөөлж, улмаар олон монгол овогтноо нэгтгэсэн (энэ удаад Өвөр Монгол-Г.Ц.) Их Монгол улсаа байгуулхын тулд шинэ Засгийн газарт ихээхэн хэмжээний сан мөнгө хэрэгцээтэй байлаа. Гэтэл эл үед монголын аж ахуйн хөгжлийн түвшин зохих хэмжээний хуримтлалыг буй болгож чадахгүй байлаа.

Анх шинэ захиргааг зохион байгуулхын тулд 1911 оны 11 дүгээр сард ХХГБХТЕЗШГ-аас (Түр засгийн газар-Г.Ц.): “Улс төрийг тулгар зохиож хүү сан болгох учир одоо 4 аймгаас найман түмэн лан хөдлөгөж, Сангийн яамнаа агуулбаас зохино”¹ хэмээн тушаасны дагуу Халхын аймгууд мөнгө цуглуулан Засгийн газар руу илгээж байсан боловч, тэр дурайхан 80 000 лан хөдөлгөж дийлээгүй бололтой байна. Нэгэн жишээ дурьдваас, Олноо өргөгдсөний тэргүүн оны өвлийн сүүл сарын хорин зургааны өдөр Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамны дэд сайд, Хан Хэнтий аймгийн чуулганы дарга, засаг, сэцэн чин ван Гомбосүрэнгээс Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэх яамнаа явуулсан бичигт: “... Сангийн яамнаа агуулбаас зохих мөнгө: харьяат аймгаас 2 түмэн лан цагаан мөнгө гаргаж хүргэн ирүүлэх ёстойгоос, олон хошуудад

¹ УТА. Ф-А6, Д1, хн 533, нугалбар 10.

хувиарлан татан авхад Улсын хүү болгох мөнгө 4700 ланг хүргүүлэн, дутуу мөнгийг даруйхан хураан явуулна.”² хэмээн мэдүүлсэн байна. Дараагийн нэгэн бичигт тус аймгаас 9700 лан илгээв гэсний дээр 18 нэр бүхий газраас нийтдээ 3300 мөнгө, 19 ланг Сангийн яамнаа илгээв³ гэсэн байх юм. Ийнхүү Халх 4 аймаг, шавь зэргээс мөнгө татварлан авч шинэ тулгар төрийн дансийг буй болгожээ.

Гэтэл тулгар төрийн маань зарлага орлогоосоо хол давж байжээ. Архивын баримтанд:” Тэргүүн оны 11 сарын шинийн ёснөөс эхлэн мөн тавдугаар оны 11 сарын 13 хүртэл улсын сангийн бүх орлого, зарлагыг байцаан бодвоос, бүгд хураасан орлого 387 524 лан 9 цэн 2 пүн 4 лий болсоны зарсан мөнгө 2 455 172 лан 8 цэн 3 пүн 2 лий лугаа харьшуулбаас илүү зарсан нь 1 717 697 лан 9 цэн 8 лий”⁴ гэснээс тодорхой харагдаж байна.

Мөн улсын санд байсан алтны нэгэн мэдээ архивт хадгалагдаж байна. Түүнд: Олноо өргөгдсөний 3 дугаар оны данснаа бүхий тусгай хуудаснаа тэмдэглэсэн хадгалан буй хэмээсэн хуучин шижир алт 23 лан, бас алтан тамга өргөмжлөл үйлдүүлсэний үлдсэн алт 5 лан 9 цэн буй. Бас хольсон алт 5 цэн 2 пү. Бас уурхайнуудаас ирсэн алтыг оруулваас нийтдээ 195 лан 1 цэн 2 пү 3 лий болохоос үзэж жигнэсэн алт 190 лан 6 цэн 1 лий 5 пү. Хуучин удаа 37 лан 5 цэн 1 пү, 5 лий тутажухуй”⁵ гэж тэмдэглэснээс үзэхэд улсын санд буй аотны хэмжээ мөн төдийлэн их биш байна.

Улсын сан хөмрөг нимгэн байсан учраас улс орноо цаашид хөгжүүлэхийн тулд удаа дараа Хаант Оросоос тусламж, зээл хүсэх болжээ. Түүхч З.Лонжид⁶, Ж.Урангуа⁷ нар Оросоос хэрхэн хэдэн удаа болон ямар нөхцөлтэйгээр Монгол улсын Засгийн газар зээл авсан тухай нэлээд дэлгэрэнгүй судлан бичсэн нь буй. Судлаачдын бичсэнг үндэслэвэл тэр үед улс орныхоо өмнө тулгараад байгаа олон асуудлыг шийдвэрлэхийн тулд Монголынхаа байгалын баялаг, гаалийн татвар зэргээр дэнчин тавин Хаант Оросоос хэд хэдэн удаа зээл авчээ. Тэдгээр зээлсэн мөнгийг Монголын засгийн газар Нийслэл Хүрээнд сууж буй Орос консулын хяналтын дор, хожим санхүүгийн зөвлөх ирсэний дараа (1914-1916 он) түүний хатуу хяналтын дор зарцуулах ёстой болсон байна. Оросын Засгийн газар санхүүгийн аргаар Монголд нэвтрэн өөрийн эдийн засгийн нөлөөг өөртөө ашигтайгаар өргөтгөхийг зорьж байсан учраас Монголын Засгийн газарт удаа дараа мөнгө, зэр зэвсгийн тусламж тодорхой нөхцөлтэйгээр өгч байжээ.

Анхны зээлийг хэрхэн авсан талаар түүхч Ж.Урангуа: “Богд Жэвзүндамба хутагтыг Монголын хаан ширээнд залах ёслолд хүрэлцэн ирсэн Халхын дөрвөн аймгийн хан нар, Хаант Орост одоод ирсэн да лам, Ханд ван, Хайсан зэрэг хүмүүс Хүрээн дэх Оросын консултай зөвлөлджээ. Энэ тухай 12 дугаар сарын 31-ний өдөр консул Люба нууц цахилгаан илгээж:”... монголын тал. Оросын эзэн хаанд талархал илэрхийлж бидний тус дэмийн ачаар тайван замаар засгийн эрхээ

² УТА. Ф-А6, Д1, хн 533 нугалбар 10, т.2

³ Мөн тэнд, нугалбар 15.

⁴ Мөн тэнд, нугалбар 2.

⁵ Мөн тэнд, нугалбар 1.

⁶ З.Лонжид. “Монгол улсын санхүүгийн албаны түүх”УБ., 1999. “Түүх сөхөхүй” УБ., 2011

⁷ Ж.Урангуа.” ХХ зууны эхэн үеийн Монгол улс”УБ.,2006. “Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс”УБ., 2010.

гартаа авлаа, цаашид энэ хүнд бэрх үед эхний ээлжинд Халхын ашигт малтмалыг барьцаалан наад захын хэрэгцээнд зориулан 100 мянган рубль болон цэргийн 10 сургагч илгээхийг хүсэж буйгаа илэрхийллээ” гэсэн баримтыг Оросын архиваас иш татан өгүүлээд мөн цааш нь: “Монголчууд 100.000 рубль, 10 цэргийн сургагч хүссэн хүсэлтийг II Николай хаан зөвшөөрчээ. Оросын Сангийн яамны сайд ийм бага хэмжээний зээлд тийм чухал баталгаа авах ч хэрэг байна уу даа гэж бичиж байсныг цохон тэмдэглэжээ.”⁸ Эзэн хаан нь ийм байр суурьтай байсан боловч эл үед Оросын талд нэгэн чухал асуудлыг шийдэх ёстой байсан учраас эл зээлийг олгох явдал Монголын асуудалтай холбогдон өрнөжээ хэмээн үзэж болно.

Ер нь Орос улс, Монголыг автономит эрхтэй улс байлгахыг хүсч байсан учраас “Монголын автономийг”⁹ хадгалхын тулд түүнийг дэмжих нь зүйтэй. Тиймээс өөрийн цэрэг армитай болох санхүүгээ цэгцлэх гэснийг дэмжиж зээл олгох нь зүйтэй гэж байжээ.

Энэ зээлийн асуудал цаашид хэрхэснийг түүхч З.Лонжид, “1912 оны эхээр Монгол Улсын Засгийн Газрын даалгавраар Гадаад Хэргийг Бүгд Эрхлэн Шийтгэх Яам, Сангийн Хамаг Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яамны сайд нар хамтарч Орос улсаас Нийслэл Хүрээнд суугаа ерөнхий консул В.Ф.Любатай биечилэн уулзаж тус улсаас 100 мянган цельковыг 10 жилийн хугацаагаар зээлж цэргийн хүнс, сургагчийн зардалд зориулахаар хэлэлцэж байхад Оросын тал уг зээлийг зөвхөн алтны уурхайгаас хураах татварын орлогоор төлж барагдуулахыг санал болгосныг М.Ханддорж, Г.Чагдаржав нар эзэн хаан ба Засгийн Газарт уламжлан зөвшөөрүүлж 1912 оны дөрөвдүгээр 25 (хаврын сүүл сарын шинийн 5)-нд дөрвөн зүйлт гэрээ байгуулан гарын үсэг зуржээ¹⁰. Үүнтэй уялдуулан 1912 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн Газар Монголор нийгэмлэгтэй гэрээ байгуулж Түшээт хан, Сэцэн хан аймгийн нутагт 20 жилийн хугацаатай алт олборлохыг зөвшөөрч, 22 зүйл бүхий тусгай дүрэм боловсруулан дагаж шийтгүүлсэн байна. Чин улсын үед тус нийгэмлэг бүх орлогынхоо 15 хувийг татварт төлж байсныг дээрхи гэрээгээр 16,5 хувь болгон нэмсэн тухай маш тодорхой судлан бичжээ.”¹¹

Ийнхүү мөнгө санхүүгийн гачигдалтай байгаагийн улмаас монголынхаа алтыг дэнчин тавин Хаант Оросоос зээл авч байжээ.

Дараагийн томоохон зээл бол 1912 онд Орос-Монголын найрамдлын гэрээ байгуулмагц Монголын тал Хаант Оросоос 2.000.000 рублийг 40 жилийн хугацаатайгаар зээлж, гаалиас жил бүр хураах 250.000 руб., уул уурхайгаас хураах 300.000 рублийг барьцаа болгон тэрхүү орлогоор төлөхөөр зээл хүсчээ. Уг мөнгийг засаг захиргаа, цэрэг зэвсгийн хэрэгт зориулна. Оросын тал:” зээлийн мөнгөний зарцуулалтанд хяналт тавих үүднээс санхүүгийн зөвлөх илгээх асуудлыг тавьсан юм. Монголын тал санхүүгийн зөвлөх шаардлагагүй, зээлийн хэмжээ бага байсан ч болно гэжээ. Зээлийн эргэн төлөгдөх нөхцлийг хангахын үүднээс “Монголор”-ын орлого болон гаалид нь хяналт тавьж болох юм. Эргэн төлөлтийн асуудлыг Консулын газар хянана, эсвэл санхүүгийн зөвлөх.... Өмнө

⁸ Урангуа Ж. Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс. УБ.,2010 т.111

⁹ Хаант Орос анхнаасаа эхлэн Монголыг автономит эрхтэй улс байлгахыг хүссэн аж

¹⁰ УТА, Ф-А6, Д.1, хн14, т.63

¹¹ З.Лонжид. Монголын тусгаар тогтнол ба алт. Судалгааны өгүүлэл. Түүх сөхөхүй УБ., 2011, т.68

авсан зэвсгийн үнэ 300.000 рублийг энэ зээллэгээс суутган авах болно”¹² гэжээ

Тус зээл нь хүүгүй байв. 1912 оны сүүлээр хүссэн зээлийн мөнгийг 1913 оны 2 дугаар сараас олгож эхэлжээ. Монголор нийгэмлэгээс орох орлогоос жил тутам нэг зуун мянган рубль саадгүй төлж байх гэрээг Монгол улс Оросын бүрэн эрхт төлөөлөгч И.Я.Коростовецтэй байгуулжээ¹³. Зээлийн 2 мянган цаасыг Монгол бригадын¹⁴ зардал болон таван замын дайнд¹⁵ зарцуулжээ.

Дээрхи 2 сая рублийн зээлийн дараа бас нэгэн багаахан зээл авчээ. 1913 оны 1 дүгээр сард дахин 2 зуун түмэн цаасны зээлийг хүүгүйгээр явахаар болж юу юунд зарцуулахыг 8 зүйлээр тодорхойлон бичиж Оросын талаас Коростовец, Монголын талаас ерөнхий сайд Намнансүрэн, Сангийн сайд Чагдаржав нар гарын үсэг зуржээ.¹⁶ Энэхүү мөнгийг “Монгол Улсын засгийн хэрэг ба цэргийн байдал, жич улсын сангийн явдлыг сайжруулахад зарцуулна. Хэрэглэх бүр МУ-ын Сангийн яамны тэргүүн сайдаас ямар хэргийн учир хичнээн мөнгө авч хэрэглэх явдлыг Консул сайдад өөрөө тодорхойлон хэлж, зөвлөн авахуулмой. Засгийн газар авсан мөнгийг ёсоор зарцуулсан эсэхийг данс бичиг үйлдэж Консулд лавлахад бэлтгэж өгнө” гэх мэтийн заалттай гэрээ байгуулан авчээ. Ийнхүү Хаант Оросоос зээлсэн мөнгийг консулын хяналтын дор, хожим нь 1914 онд Оросын зөвлөх түшмэл ирсэний дараа түүний хатуу хяналтын дор зарцуулах ёстой болжээ.

Мөн түүнчлэн 1914 онд 3 сая рублийг 30 жилийн хугацаатайгаар, хүү тооцохгүйгээр авчээ. Энэ удаагийн зээлийг дотоодын шинэтгэлийн бодлогод зарцуулах бөгөөд мөн л Хаант Оросын санхүүгийн хяналтын дор зарцуулахаар тогтжээ. Зээлийн нэгдүгээр ээлжийн 1 сая рублийг гэрээ байгуулагдмагц олгоно, үлдсэнийг 500.000 мянгаар нь 6 сар тутамд олгоно. Зээлийн сүүлийн хэсгийн авснаас хойш монголын тал жилдээ 100.000 рублийг гааль болон гадаад худалдааны татвараасаа төлөх нөхцөлтэйгээр зээлсэн байна. Зээлийн гэрээг 1914 оны 9 дүгээр сарын 17-нд Хиагт хотноо байгуулжээ.

Хаант Орос 3 сая цаасны зээл олгохдоо хэд хэдэн болзол тавьсны нэг нь Өвөр Монголоос дайтаж буй цэргээ татах явдал байлаа.

Дэлхийн дайн эхэлсэнтэй холбогдон энэ зээлийг олгох асуудалд Оросын талд нэлээд асуудал гарч, монголчуудад зэр зэвсэг нийлүүлэхэд хүндрэл үүсчээ. Зээлийн мөнгөний сүүлийн 1 сая-ийг олгох асуудал хойшлогдсоор байтал 3 сая рублийн зээлд хяналт тавих үүрэгтэй Санхүүгийн зөвлөхийн гэрээний хугацаа дуусч байна. Тэгээд ч санхүүгийн зөвлөх нь зээлийн мөнгөний зарцуулалтанд хяналт тавьснаар Монголын Засгийн газарт бидний ач тусыг байнга сануулж байх ёстой хүн. Гэтэл монголчууд түүнийг илүүдэл хүн хэмээн үзэж байгаа зэргээс хамааран зээлийн үлдсэн 1 сая дутуу мөнгийг олгох шаардлага байна уу? гэсэн асуудал ч тавигдаж байжээ. Гэвч олгохоор болсон байна.¹⁷

¹² Ж.Урангуагийн номноос дам ишлэв. РГИА. Ф-1276, Оп. 7, Д.463.

¹³ Коростовец И.Я. От Чингис хана до Советской Республики (Краткая история Монголии с учётом новейшего времени) УБ., 2004, стр.367.

¹⁴ Орос сургагчидтай монгол цэргүүдийг оросууд “Монгол бригад” хэмээн нэрлэж байжээ.

¹⁵ Өвөр Монголыг чөлөөлөх дайн.

¹⁶ УТА, Ф-А4, Д.1, хн 136.

¹⁷ Ж.Урангуа. Монголын тусгаар тогтнолд Хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс. УБ., 2010, т. 76

Ингээд зээлсэн мөнгө цаг тухайд нь төлсөөр иржээ. Олноо өргөгдсөний 7 дугаар (1917) оны намрын сүүл сард Дотоод яам болон Сангийн яамнаас Богд хаанд илгээсэн нэгэн нугалбарт: “Орос улсаас гадаад, дотоодын гааль татвараас батлан гэрээ байгуулж зээлсэн олон зуун түмэн цаасыг төлөх хугацаа нэгэнт гүйцэд эхэлж төлөхүйд жил бүр хорин долоон түмэн цаас эргүүлэн төлөх зэргийн олон бэрхшээлтэй учир гаргаж эл дутагдал буй зарлагыг яаж хүрэлцүүлэх ба дутсан үлэмж өрийг хэрхэн төлж ариутгах аргыг эртхэнээс зөвлөлдөн тогтооё хэмээсэн нэгэн хэргийг Дотоод яамнаас Улсын хуралд хэлэлцүүлэхээр зөвлөн гаргасан нь нөгөө яамууд хэрхэн толилсоныг мэдэгдэж ирээгүй ба үүний урьд зарим түшмэдээс улсын санг аривжуулах тухай алба татварлах зэргийн арга санал гаргаж хурлаар хэлэлцүүлэх удаа бүр олон аймгийн үнэн хөрөнгийг мэдээгүйд албан томилж бэрхшээлийг хэлэлцэн түтгэлзүүлжүхүй. Бас эргэцүүлэн хянаваас, улсын сангийн орлого нь төлөв гаалийн зүйлд итгэх боловч хэрэглэхүйд огтхон ч хүрэлцэхгүй өчнөөн үлэмж зардал тогтоосон ба бас ч энэ хир зах хязгаарыг сэргийлэн батлах цэрэг дайчлах, мордуулах зэрэг хэрэг дараалан гарч бүхийг үзвээс цалин хэрэгсэх явдал нэн ч чухал холбогдоход хүрэх буй за”¹⁸ гэснээс үзэхэд хамгийн сүүлийн томоохон зээл болсон 3 сая рублийг эргүүлэн төлөх хугацаа дөхөх үед эл асуудалд олны анхаарал ханджээ.

Сангийн яамнаас эл үед олон түмэнд хандан сайн дураар мөнгө хандивлах эсвэл тусгайлан бичиг үүлдэж, хувь хүмүүсээс зээлээр мөнгө авах асуудлыг Улсын Доод болон Дээд хуралд өргөн барьжээ. Энэ тухайд түүхийн эх сурвалжинд: “Эдүгээ улсын санхүүгийн зүйл огтхон ч хүрэлцэхгүй явцуудсан чухал цаг олон нийтээр хүчээ гүйцэтгэн зүтгэх онолыг хувь илүү хэрэгсэх буй за. Хэрвээ бат илэрхийлэх тэмдэгт бичиг хүлээн авахыг хүсэхгүй, дуртайяа хариулан өргөх нь буй аваас тухайг үзэж зарлигийг гуйн айлтгаж хөхүүлэн хөгжүүлэх зүйл байх болов уу хэмээх учрыг хамтаар гаргаж улсын хуралд өргөн мэдүүлээд олдвоос толилон тогтоож гүйцэтгэн шийтгэх ажаамуй. Үүний тул өргөв хэмээн өргөсөн нь Доод хуралд үзэж хянаваас ийнхүү төгсгөсөн хэргийг үлгэрлэж тус улсын сайд түшмэдээс энгийн ардад хүртэл чинээ чадахыг харгалзан хугацаагаар мөнгө зээлдүүлэх буюу дуртайяа туслуулж сангийн зүйлийг аривжуулах хэмээсэн нь үнэхээрийн зүйтэй болов уу хэмээвч хэрхэхийг Дээд хурлаас лавлан тогтоолгоё хэмээжүхүй. Дээд хуралд үзвээс ийнхүү санал гаргасан ба Доод хурлаас цохсон нь цөм үнэхээрийн зүйтэй. Ёсоор явуулбаас зохихын тулд Дотоод, Сангийн хоёр яамнаас айлтгаж нийтээр зарлан гүйцэтгэвээс зохимой хэмээн цохсон тул үүнийг Дотоод, Сангийн хоёр яамнаа тус бүр сийрүүлэн явуулаад байцаан үзэж түүгээр гүйцэтгэн шийтгэх ажаамуй. Ийнхүү учрыг Гадаад зэрэг нөгөө гурван яамнаа явуулаад байцаан үзүүлье. Үүний тул илгээв хэмээн хүргэж иржүхүй”¹⁹ гэсэн олон түмэнд хандсан, нийтийн хүчээр зээлсэн мөнгийг эргүүлэн төлөх тухайд санал гарч байжээ.

Улмаар Монгол улсын дотор хугацаагаар мөнгө зээлэн авч чухал хэрэглэхүйд тус болгох явдлыг айлтгаад зарлиг ёсоор болгосоныг дагаж шийтгүүлэхээр Нийслэл Хүрээний Гаалийн баруун, зүүн хорооны түшмэдийн зэрэг дөрвөн

¹⁸ УТА, Ф.А6.Д1, хн 1091, нугалбар 20.

¹⁹ Мөн дээрх.

газар тушаан явуулсан бичигт мөнгө улсдаа хандивлах нь.” Бас ч энэ болбоос албан татварлах хэрэг бус цагийг дагаж урьд зээлэн аваад хойш төлөн өгөх нь ялгавартайн дээр бидний монголчууд Очирдара богд эзний ач авралаар амар жимэр хүрсэндээ цэнгэлдэн аж төрж бүхийн тулд бүрнээ хувь зохиолтой сэтгэлээр өөр өөрийн хүчин чадахын чинээгээр үлэмжхэн мөнгө зээлүүлэн өгч сааргүй хэрэглэх зүйлд тус болговоос зохих учрыг ухуулан хир чинээ буй агаад хоосон нэр тоо хийж өчүүхэн бага гаргаваас чухал хэрэгт тусыг хураан чадахгүй тул эргүүлэн нэмүүлж бүх зээлэн авсан мөнгөнийг арван таван жилийн хугацаа хугацаж хойш төлөн өгсүгэй”²⁰ гэжээ. Хэрэв сайн дураараа эргүүлэн авахгүйгээр өгвөөс тэр хүнийг хөхүүлэн шагнах болжээ. Хэдий хэмжээний мөнгө улсын санд хандивласныг нь харгазан юугаар шагнах тухай тусгай дүрэм хэмжээ гарган мөрдөж байжээ.²¹

Тийнхүү ард иргэддээ хандахдаа учир байдлыг сайн ойлгуулхийг чухалчилж:” Энэ болбоос санхүүгийн зүйл хүрэлцэхгүй маш явцуудсан чухал цаг тусыг хураах арга үүсгэн шийтгэж” байна гэдгээ мэдэгдэж байв. Тэгээд эцсийн бүлэгт Монгол улс Оросоос зээлсэн сүүлийн 3 сая рублийг төлж дуусгахаар завдаж байтал Орос оронд Октябрийн хувьсгалч гарч, тус оронд тогтсон Зөвлөлт засаг Монголын өрийг хүчингүй болгосон юм.

XX зууны эхэн үеийн монголын улс төрийн зүтгэлтнүүдээс зээлийн асуудалд анхаарал тавьж, зээл авах нь тийм ч оновчтой арга зам биш юм. Харин бид өөрсөддөө байгаа нөөц бололцоогоо шавхан дайчилж, орлогын эх сурвалж олох хэрэгтэй хэмээн үзэж байжээ. 1914-1919 онуудад хуралдаж байсан Улсын Дээд, Доод хурлын дансыг үзэхэд Доод хуралд оролцогчдын дотор ард олны хүсэл эрмэлзлэлийг илэрхийлэгчид цөөнгүй байсан бөгөөд тус орны эдийн засагт төрж байсан, шинэ маягаар аж ахуйгаа эрхлэгчид, хөрөнгө мөнгөө арвижуулах гэсэн болон ер нь дэвшилт, шинэлэг үзэл бүхий хүчнүүд цөөнгүй байв. Энэхүү улсын хурал тэр үеийн монголын нийгэм дэх улс төрийн хүчнүүдийн үзэл санаагаа илэрхийлэх талбар болсон бөгөөд нийгмийн дэвшилт хүчнүүд түүнийг өөрсдийн шинэтгэлийн үзэл бодлогыг биелүүлэхэд ашиглахыг оролдож байжээ. Үндэсний Төв Архивын сан хөмрөгөөс үзэхэд 1914-1919 оны хугацаанд улс орны хувь заяатай холбоотой 90 бичиг Улсын Хурлын газарт иржээ²².

Шинэ Монгол улсын Засгийн газар үндэсний эдийн засгаа өөд татах зарим оролдлогуудыг хийж эхэлсэн юм. Монголын тэргүүний хүмүүсээс феодалын алба гувчуурыг хөнгөтгөх, ард түмний аж ахуйн санаачлагыг тэтгэх, ардын доторх эрдэмтэй, чадалтай хүмүүсийг язгуур угсаа харгалзахгүйгээр улс төрийн үйл ажиллагаанд оролцуулах, иргэний сургууль соёлыг хөгжүүлэх шаардлагыг тавих нь хүчтэй болсон ба нөгөөтэйгээр эрх баригчдын ухамсартай хэсэг нь энэ мэтийн шинэтгэлийг хийхгүйгээр урагш хол явахгүй гэдгийг ухаарч байлаа. Зарим жишээ дурьдвал: захирагч Бадрахбаатар, далай ван Цэрэнсодномтой нэр хавсарч Улсын Дээд, Доод хуралд оруулсан саналдаа, монголчууд Чин улсын харгис засгаас салж төрөө сэрээж тусгаар улс болсон тул санхүүг зузаатгах, алба гувчуурыг хэмнэж

²⁰ УТА. Ф. А6, Д-1, хн 1091.

²¹ Ж. Урангуа. Монгол төрийн соёрхол. УБ., 2011, т. 100

²² “Монгол УЛсын Дээд, Доод Хурал. Баримт бичгийн эмхтгэл II (1917-1918). Эмхтгэсэн Ж.Гэрэлбадрах, Ү.Дэлгэрмаа, Э.Жавзандулам. УБ6, 2005, т.10.

аж төрөх ардын хөрөнгийг хайрлах, сургууль нээж, бичгийн журмаар улсыг засах, цэргийн эрдмийг боловсруулах, сүрийг бадруулан төрийг тогтоох нь эрх баригчдаас улсын засгийг явуулахад итгэжээ. Улс гүрний мандсан, мөхсөн нь их төлөв өршөөл явуулж, хөрөнгийг арвилаж, иргэдийг хайрлаж, үнэнийг эрхэлсэн эссэнээс болжээ. Тустай хэргүүдийг харштай болуузай гэж эргэлзэн татгалзаж, өдөр удаад харин санамсаргүй дотоод, гадаад улсад үнэмлэгдсэн хөрөнгө алдаж, хүний сэтгэл хувьсахад хүрвэл яахан нэхэж гэмшивч үл гүйцэх үед хүрнэ. Тус нэмэртэй үнэн зөв хэрэг байвал урьд нэгэнт тогтсон хэмжээ хэмээхийг огт баримтлахгүй цагийг дагаж байдалд нийцүүлэн хүчин төгс болгон урьдахийг хувьсган нийтийг амар жимэр болгох ажаамуу, засгийн хэрэг, нэр төрийг гутаахгүй болгоход тус болгоход зориулсан болохоос урьд нэгэнт шийтгэсэн олон хэргийг мушгих шүүмжлэх нь бус засах, тэгшилэхэд зориулав” хэмээгээд, санг арвилан хэмнэх хэрэгтэй эс тэгвэл голын эхийг бөглөж, урсгалыг хол болгох, үндсийг цавчиж модыг өндөр болгох гэсэнтэй адил бөглөө. Засгийн газрын цалин пүнлүү г хүртэх, албан зарлагыг дотроос нь хэмнээд санг арилгах, Хятадын пүүсүүдэд төлөх өр нь Чин улсын ховдог түшмэл, харгис засагт дарлагдаж аргагүйн эрхээр байгуулсан өр учир нэхэмжлэхийн чинээгээр төлөх аваас хөрөнгө хүртэхгүй тул чадвал огцроох, эс чадвал хувь хорогдуулах Хятадаас найрамдлыг эрхлэн бүхий дор энэ зүйлийг тулган шийдэхийг хичээвэл зохино. Уул тахих, сур намнаж харвах нь хуучин цэргийн сургууль. Одоо цагт аль ч газар эс хэрэглэх тул илүү зардлыг хэмнэх, баян аж төрөхтэй лам ноёдоос болон хурлын жас нараас хэр хэрээр мөнгө цаас татах, өртөөний суурийн тоог хасаж цөөлбөл зохино “гэж бичиж байжээ. Үүнээс өртөөдийн тоог л цөөлсөн байна.

Дээрх санал, санаачлагууд нь чухамдаа өөрийн улсын үндэсний биеэ даасан эдийн засгийг буй болгон хөгжүүлэх, доройтож хөөрхийлөлтэй болсон ард, түмний аж байлдлыг өөд татахад байгаль орчинтой зохицсон харьцаанд чиглэсэн чухал ач холбогдол бүхий санал, эрэлт шаардлага байжээ. Засгийн газар, тэдгээрийг үндэслэн эдийн засгийн талаар явуулсан бодлого, арга хэмжээ тухайн үедээ шаардлагатай, дэвшилтэй зүйл байсан нь маргаангүй.

Өгүүлэн буй үед улс орны санхүүгийн байдал нилээд хүнд байжээ. Ард иргэд нь их өртэй, нүүдлийн мал аж ахуй амиа аргацаасан шинжтэй, үйлдвэрлэл бараг байхгүй байв. Дайчин Улсын банкны салбар тус оронд 1912 оны эцэс хүртэл үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байсан бөгөөд тус банкинд төлөх монголчуудын өрийг “Монгол үндэстний нэвтэрхий түүх” зохиолд: “...дунджаар нэг өрхөд 500-1000 лан мөнгө, ихэс дээдэс нарын өр нийт дүнгээрээ 11 сая лан мөнгөнд хүрсэн гэж”²³ бичжээ. Оросын худалдааны экспедиц Хятадын пүүсүүдэд төлөх Монголын нийт өр 10 сая рубль буюу 804600 лан байсан хэмээн тооцоолсон мэдээ бий²⁴. Өрийн асуудал улс орны санхүүгийн чадавхид маш муугаар нөлөөлж байсан нь ойлгомжтой.

Монголын санхүүгийн албаны түүхийг судласан түүхч З.Лонжид: Монгол улсын засгийн газар хөрөнгө мөнгө дутагдалтай байсан учраас хятадын дээрх банкнаас зээл авах санал олон удаа тавьж байсан ба өрөө барагдуулбал Монголын

²³ “Монгол үндэстний нэвтэрхий түүх”. Бээжин 1995, т.205.

²⁴ Ширэндэв Б. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1969, т.63.

Засгийн газарт мөнгө зээлүүлж болох юм гэж боогдуулж байлаа. Тиймээс Монголын Засгийн газар Сангийн яамандаа хугацаатай үүрэг өгч уг банкны шаардсан өрийг ямар нэгэн аргаар төлүүлэхийг хичээж бүх аймаг шавьд бие хүн албаны түшмэд илгээж дахин давтан шаардсаны үрээр 1913 оны эцэст уг банкинд төлөх өрийн 25 орчим хувийг арайхийж гүйцээсэн боловч мөнгө зээлж чадаагүй тухай бичжээ²⁵.

Ер нь зээлийн асуудалд болгоомжтой хандах нь зүйтэй гэж Монголын эрх баригчид үзэж байсан хэдүй ч нөхцөл байдал мөнгө хөрөнгө шаардсаар байжээ. Ерөнхий сайд Т.Намнансүрэн Орост айлчлах үеэрээ Францын нэгэн хувийн компани хүмүүстэй уулзаж, Монголын Засгийн газарт зээл олгох банк олох асуудалд дөхөм болохыг гуйсан хэргийн тухай Оросууд мэдээлэл авмагц, Намнансүрэнгээс эл талаар тайлбар өгөхийг шаардахад тэрээр зээлийн тухай асуудал огт яриагүй хэмээн хариулсан байна. Эрх баригчид улсын дотоодын орлогын эх үүсвэр олох асуудалд ихээхэн анхаарал тавьж байжээ.

Эл үед улсын төсвийн орлогын 1/4-ийг гаалийн хураамж бүрэлдүүлж байв. 1912 оны зун Гаалийн хэргийг бүгд захиран шийтгэх яамыг байгуулж, салбар хороодыг Хиагт, Улиастай, Ховд зэрэг хотноо нээн дотоод, гадаад худалдаанаас гааль хурааж эхэлсэн нь улсын санхүүг бэхжүүлэх явдалд чухал ач холбогдолтой орлогын эх үүсвэр байлаа. Түүхч Б.Ширэндэвийн бичсэнээр бол гаалиас жил бүр 150 мянган рублийн ашиг олдог байжээ²⁶. Оросоос зээлсэн мөнгийг эргүүлэн төлөхөд гаалийн орлого багагүй үүрэг гүйцэтгэж байжээ.

1913 оны VII сарын 11-нд Монголчуудын дотоод худалдаанаас гааль хураах тухай дүрэм баталжээ. Харамсалтай нь энэ нь 1912 онд Орос-Монголын хэлэлцээрээр тус оронд гаальгүй худалдаа хийх эрхийг олж авсан Оросын худалдаачдад хамаарахгүй байсан ажээ. Дотоодын гааль ийнхүү Монголын түүхэнд энэ үед анх үүсчээ. Энэ нь хэдийгээр улсын гол орлогын эх сурвалж болох болсон авч дотооддоо худалдааны гүйлгээ өсөх, нэгдмэл зах зээл үүсэхэд садаа болж байв.

Гадаадынханд алтны уурхай түрээслүүлснээс хураах төлбөрийг нилээд нэмэгдүүлжээ. Энэ үед нийтдээ алтны уурхай 15-ыг ашиглаж байсан ба тэдгээрт 2500 гаруй хятад, 250 орчим орос ажилчид, монгол ажилчин 70 байжээ. Оросын хувь нийлүүлсэн “Монголор”-оос хураах татвар жилд 350 мянган рубль болдог байв. Гадаадынхан тус орноос олзворлосон баялгаа шууд гадагш гаргаж байсан тул тус орны үндэсний эдийн засгийг хөгжүүлэхэд нааштай нөлөө үзүүлэхгүй байв. Гэхдээ тэр үед бий болсон аж ахуйн үйл ажиллагааны түрээсийн хэлбэр нь шинэ зүйл байлаа. Сүм хийдүүд малаа түрээслүүлэн хариулуулах, гадаадынханд газар түрээслүүлэх зэрэг түрээсийн үйл ажиллагааны олон хэлбэр буй болж байв. Энэ нь хамжлагын харилцаа задарч, капиталист харилцааны үр хөврөл соёлох үед бий болдог аж ахуйнууд ашиг олохын үүднээс хийдэг үйл ажиллагаа юм.

Монгол улсын хэрэгцээнд зээллэг олгох гадаадын банк тэр болгон байхгүй байгааг харгалзан Засгийн газар өөрийн зээллэгийн хэргийг цэгцлэн байгуулах

²⁵ Лонжид З. Монгол Улсын санхүүгийн албаны түүх (1911-1921).УБ., 2000, т.14.

²⁶ Ширэндэв Б. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1969, т.56.

болсон юм. Засгийн газар үндэсний зээллэгийн байгууллагын тухай дүрмийг Богд хаанд толилуулахаар 1917 оны XI сарын 24-нд оруулжээ. Тэрхүү дүрмийн ёсоор уг байгууллагын мөнгө хөрөнгө нь лам ноёд нарын хувь оруулсан мөнгө хөрөнгөнөөс буй болгоно. Хүмүүст зээл олгохдоо тухайн хүний хөрөнгөний байдлыг харгалзан тодорхой хугацаагаар, зохих хүүтэйгээр өгдөг байжээ. Улс мөнгөн хөрөнгөөр ихээхэн дутагдаж байгаа үед зээлийн энэ санд хандив өргөхийг Дээд, Доод Хурал, ноёдод хандаж 1917 онд хүссэн байна. Хэрэг дээрээ мөнгө ингэж цуглуулах нь албат ард ба шавь нарын хувьд бас л нэг албан татвар болж байжээ. Зээллэгийн энэ байгууллагын үндсэн хөрөнгө нь 1918 оны тайлангаар 4048130 рубль байсан, үүнээс 3293590 рублийн зээллэгийг албан газрууд, энгийн хүмүүст олгосон байжээ.

Монголчууд өөрсдөө улсын банк байгуулах тухай улсын хуралд оруулсан саналдаа Оросын жуулчдын тэмдэглэлээс үзэхэд дөрвөн аймаг, шавь, Ховдын хязгаар, Дархадын зэрэг газруудын тэмээ оролцоогүй бусад мал 17 сая гаруй байх тул бод нэг бүрээс 50 мөнгө, бог малаас 10 мөнгөөр бодож татвар оногдуулан бодвол 3 сая гаруй мөнгө хуримталж болох бөгөөд үүгээрээ мөнгөн санхүүгийн банк байгуулж болох бололцоотой байна гэсэн саналыг 1916 оны 2-р сард Бадрахбаатар тавьжээ. Үүнийг нь Улсын Дээд хурлаас, шашин хурлын мал сүрэгт албан татвар ноогдуулах гэсэн хортой санал хэмээн няцаан буруушаажээ. Хэрвээ энэ саналыг дэмжсэн бол ашиг тустай зүйл болох л байсан. Гэтэл Оросын хөрөнгөтнүүдэд “Монгол үндэсний банк” нээх эрх олгосон билээ.

1914 оны VII сарын 2-ны өдөр Хаант Оросын Сайд нарын танхимын хуралдаанаас Монголд томоохон банк байгуулах шийдвэр гаргасан. Энэ нь Монголын зах зээлийг нөлөөндөө оруулж, Оросын бараа таваарыг Монголд оруулах зорилготой байжээ. Монголын Засгийн газартай тохирсон анхны хэлэлцээрээр уг банк нь Монголын албан ёсны байгууллагуудад мөнгө зээлдүүлэх ба үндэсний банкны тэмдэгт цаас гаргахад туслах ёстой байсан боловч энэ үүргээ гүйцэтгээгүй. Гэхдээ энэ тухай асуудлыг хэлэлцэж байсан тухай баримт байдаг. Тэр үед Монгол улсад үндэсний мөнгөн тэмдэгт гэж байсангүй, хятадын янчан, металл мөнгө, оросын целков буюу рубль, империал хэмээх алтан зоос, мексик, америкийн доллар зэрэг олон улсын тэмдэгтээр худалдаа гүйлгээ хийж байлаа²⁷. Зарим нутагт арилжааны гол эквивалент нь мал (хонь, үхэр) болж байв.

Хаант Оросын энэхүү банк нь 1915 оноос үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд энэ банкны нэг онцлог нь зөвхөн худалдааг санхүүжүүлэх зорилготой бус мөн өөрөө худалдаа арилжаа хийж байв. Тус банк нь Оросын ба гадаадын хүмүүс, монголчуудад өндөр хүүтэй мөнгөн зээллэг олгож байжээ. Монголын Засгийн газар шинэчлэл хийх хэрэгцээнд зээл олгохыг Оросын банкнаас 1915-1917 онд хүссэн боловч уг банк нь татгалзжээ. Монголын Засгийн газар уг банкны удирдлагын үл бүтэх хандлагыг эсэргүүцэж, Нийслэл Хүрэн дэх Оросын ерөнхий консулд 1918 оны намар нот явуулж уг банкиг устгахыг шаарджээ²⁸.

Монголын нийгэмд төрж байсан хөрөнгөлөг хүмүүс нь мөнгө хүүлж байсныг нотлох баримт нилээд байна. Тэд хятадын пүүсүүдэд хувь нийлүүлж мөнгөө

²⁷ Лонжид З. Монгол Улсын санхүүгийн албаны түүх (1911-1921) УБ., 2000, т.11.

²⁸ Ширэндэв Б. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1969, т.27.

үржүүлэх, хувиараа зээл өгөх зэргээр үйлдвэрлэлийн бус хүрээнд хуримтлал буй болгож байв. Эдгээр баячууд нь худалдаа, мөнгө хүүллийн аргаар хуримтлуулсан мөнгөнийхээ зарим хэсгийг худалдаа хийх, мөнгө хүүлэх капитал болгон үржүүлж байсны зэрэгцээ зарим нь жин тээх, өртөө улаа ацаглах, морь тэмээ бэлтгэх, газар тариалангийн ажилд оруулах зэргээр ашиг олох салбарт оруулж байв. Мөнгө хүүлэл нь үйлдвэрлэлийн шинэ аргыг бий болгодоггүй, мөлжмтгий шинж чанартай ч гэсэн нийгмийн гүнд шинэ үйлдвэрлэх хүчний элемент бүрдүүлэх таатай нөхцлийг бүрдүүлдэг бөгөөд нийгмийн давхраажилтанд түлхэц өгч байсан байна.

Эцэст нь Хаант Оросоос зээлсэн мөнгө хэд нь төлөгдөж, хэд нь үлдсэн тухайд Сангийн яамны дансанд:” Орос улсаас анх зээлэн авсан 10 түмэн цааснаас 2 дугаар оноос эхлэн жил бүр 1 түмэн цаас төлөөд одоо 5 түмэн цаас дутуу. Хоёрдугаар удаа зээлэн авах хэмээсэн 2 сая цааснаас 1сая 7 бум 5 түмэн 1мянга 136 цаас 95 мөнгө аваад одоо дутуу 2 бум 4 түмэн 1863 цаас 5 мөнгө. Үүнийг Орос засгийн газраас зохих цагт эс авсан учир Петербурgt хоцорсон хэмээсэн ба үүний дотроос 9 түмэн 4766 цаас 1 мөнгө хагасийг Монгол засгийн газар олгосон зэвсгийн үнэнд суутган төлвөөс зохимой хэмээжэхүй. Гуравдугаар удаа зээлэн авах хэмээсэн 3 сая цааснаас 4 дүгээр онд авсан 6 бум, 5 дугаар онд авсан 5 бум, 6 дугаар онд авсан 8 бум 4 түм 5 мянга, бас консул сайдын газар авч хоцроод Монгол засгийн газрын төлөө зарсан 5 түм 5 мянга. Эдгээр бүгд 2 сая болжихуй. Эдгээр 300 түмэн цаасыг Олноо өргөгдсөний 4 дүгээр оны 8 сарын 11-нээс хойш нэгэн сарын дотор 1 сая-ийг өгөхөд үлдсэн цаасыг зургаан сар тутам 50, 50 түмэн цаас авмой хэмээсэн хугацаа 6 дугаар оны 9 сарын 11-нд гүйцмөй. Үүнээс дээш төлвөөс зохих бүгд цаас нь, анхны удаа зээлсэн 10 түмэний 50,000 цаас хоёрдугаар удаа зээлэх хэмээсэн 2 сая-ийн 1 758 138, 136 цаас 95 мөнгө гуравдугаар удаа зээлэх хэмээсэн 3 сая-ийн 2 000 000 цаас, бүгд нийлж 3 808 136 цаас 95 мөнгө болмой²⁹” гэжээ.

Ингээд Орос улсаас зээлсэн мөнгөний тухайд нэгтгэн дүгнэвээс: Монгол улс хувьсгалын зорилтуудаа хэрэгжүүлхийн тулд хойш хөршөөсөө нилээд хэмжээний зээл авч, улмаар эргүүлэн төлөлж байсан боловч үлэмжхэн хэмжээний өртэй байсан болсон бөгөөд Орос оронд тогтсон ажилчин тариачны Зөвлөлийн засаг Монголын өрийг хүчингүй болгож, Монгол улс энэ удаад өргүй болсон түүхтэй.

Abstract: *When in the 29th of December of 1911 the Mongols established own state for strengthening it and liberation own territory from the Manchu-Chinese troops and unite the rest of Mongolia under the mongol rule need a huge amount of financial sources. So make the fund rising in the Mongolian ground was impossible. For that purpose the mongols seek the financial aid from Russia and heavily talk how the mongols should have own financial sources and how payback the Russian loan and how the mongols should develop their finance ability. All those internal policy moods in the Mongolian society described in this article using the historical sources of that time.*

²⁹ УТА Ф-А6, Д1, хн 1073, нугалбар 3